

Ойн нөхөн сэргээлт

Байгалийн аясаар эсхүл хүний оролцоотойгоор ойн модны шинэ үе бий болж нас бие гүйцсэн хөгшин модыг орлодог үйл явц юм. Ойжуулах ажлын үндсэн зорилго нь ойг нөхөн сэргээх явдал юм. Ойн нөхөн сэргэлтийг байгалийн өөрийн аясаар болон зориудаар хэмээн хоёр ангилдаг.

Байгалийн өөрийн аясаар нөхөн сэргээх явц



Үрээр нөхөн сэргээх

Ойд ургаж байгаа модноос шинэ мод төлжиж ургахыг байгалийн сэргэн ургалт гэнэ. Сэргэн ургаж байгаа явц нь зөвхөн байгалийн өөрийн аясаар явагддаг. Мэргэжлийн хэллэгээр бол эх модноос үржиж бий болсон шинэ ой гэж нэрлэдэг. Модны үр газарт унах, салхинд хийсэх, төлжиж залуужих гэх мэт замаар шинэ ой ургаж бий болдог. Шинээр ургасан ойг дотор нь үрийн, залуужсан, хосолмол гэж хуваадаг.

Танд бас нэгэн нууц хэлж өгье! Жишээлбэл энэ юу гээч ...

Салхинд хийсэж эсхүл эх модноосоо тасарч газарт унах явцыг байгалийн аясаар үрээр нөхөн сэргээх гэнэ. Үр цаашдаа амжилттай ургах хамгийн таатай нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай. Нялх хүүхдийг хайрлан асарч өсгөдөгтэй ижил үрийг ч мөн ингэж бойжуулдаг. Байгалийн аясаар үржсэн нас бие гүйцсэн модыг (эх мод гэж нэрлэдэг) ой судлаачид өсөлтийн үеэс нь сонгон авч цаашид бойжуулдаг. Ойд зориудаар хамгийн эрүүл чийрэг модыг үлдээж өвчилж гэмтсэн, хорчгор модыг нь огтолдог.

Залуужиж нөхөн сэргээх

Байгалийн аясаар залуужиж байгаа нөхөн сэргэлтийг хожуулын болон үндэснийх гэж ангилдаг. Хожуул болон том модны үндэснээс салаалан ургаж байгаа найлзуураар нь ангилж байгаа юм. Мод бэлтгэлээс үлдсэн хожуулаас найлзуур ургаж ой нөхөн сэргэдэг.

“Агаарын довтолгоо” буюу салхинд хийссэн үрийн талаар дуулсан уу? Ой судлалд салхинд хийссэн үрээс ургасан ойг ингэж нэрлэдэг юм.

Хосолмол нөхөн сэргээлт

Байгаль өөрөө нөхөн сэргэнэ – зарим зүйлийг хүний оролцоотой хийнэ! Ингэж бие биенээ нөхөж хамтран ажиллах нь хамгийн шилдэг арга юм. Ой нэгэнт байгалийн аясаар сэргэх боломжгүй болсон тохиолдолд хүний оролцоотойгоор ойжуулалтын ажил хийдэг.



Сайн байцгаана уу? Шинэ ой хэрхэн үүсэж бий болдгийг та мэдэх үү? Ойжуулалт гэж юуг хэлдэг вэ?



Зориудаар нөхөн сэргээх

Хүний оролцоотойгоор ойг зориудаар нөхөн сэргээдэг. Үүнд үрээр (тарих) ургуулах эсхүл тарьц, суулгац шилжүүлэн суулгаснаар ижил настай модноос бүрдсэн ой ургадаг.

Ойг зориудаар нөхөн сэргээхэд ямар ДАВУУ болон СӨРӨГ тал байдгийг мэдэх үү?

Зориудаар нөхөн сэргээхийн давуутай тал

- » сор модноос гаргаж авсан тарьц, суулгац ашиглах боломжтой
- » таримал ой өтгөн, жигд, цэгцтэй ургадаг
- » таримал ойд менежмент явуулах, тайралт, сийрэгжүүлэлт хийхэд тохиромжтой
- » эх модны үрийн жилээс хамааралгүй

Зориудаар нөхөн сэргээхийн сөрөг тал

- » нүцгэн талбайд сүүдэрлэх мод ургуулах зорилгоор тарьц, суулгац суулгах боломж бага
- » дан бүрэлдэхүүнтэй ой бий болох – monoculture
- » мал, ан амьтан хохирол учруулах магадлал өндөр, ялангуяа хашаа хатгаагүй тохиолдолд
- » өртөг өндөр (суулгацын үнэ + ойн талбайд шилжүүлэн суулгах ажлын хөлс)

Ойг нөхөн сэргээх нь маш их ажиллагаа шаарддаг! Ямар ямар ажил хийх шаардлагатай байдгийг мэдэх үү?

Ойд нөхөн сэргээлт хийх ажлын бэлтгэл

- » зэрлэг ургамлыг түүж цэвэрлэх
- » хөрсний чанарыг сайжруулах – сийрэгжүүлэх
- » хөрсөө бордож чийглэнэ
- » тохиромжгүй мод, бут сөөг болон мод бэлтгэлээс үлдсэн хог хаягдлыг зайлуулна



Гар аргаар ухсан нүхэнд тарьц, суулгацаа суулгаж ойжуулах ажил хийдэг. Бүх төрлийн тарьц, суулгацыг шилжүүлэн суулгадаг. Нүхээ гар аргаар хүрээ, жоотуу, лоом эсхүл нүхлэгч багаж ашиглан ухна. Үндэсний систем нь шулуун, өтгөн саглагар бус ургамлыг завсар гарган суулгадаг (štěrbinová) аргыг өргөн хэрэглэж байна. Төрөл бүрийн багажаар тарьц, суулгацаа суулгах нүхээ ухаж бэлтгэнэ.

Ихэвчлэн хавар эсхүл намар тарьц, суулгацаа шилжүүлэн суулгадаг. Хавар газар гэмсэгц шилмүүст болон навчит модны бүх төрлийг суулгана. Намар шилмүүст модны төрлөөс шинэс, навчит модны бүх төрлийг суулгадаг. Бүрхэг, сэрүүн ялангуяа бороо орсны дараа суулгах нь хамгийн тохиромжтой. Бортоготой тарьц, суулгацыг улирлаас хамааралгүй шилжүүлэн суулгах боломжтой бөгөөд энэ нь бортоготой тарьц, суулгацын давуу тал юм.

